



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives
Resilient nations

“БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН СҮЛЖЭЭ” МОН/13/303 ТӨСӨЛ

“ГҮЛЗАТ”

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

НУТГИЙН ИРГЭДЭД
ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН
МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР




“ГУЛЗАТ”-ЫН ОНХГ

НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН
ЗАГВАР

ОНХГ-т авсан зорилго:


- Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумын нутаг улсын хил орчмын 126,772 га газрыг ховор болон агнуурын амьтдын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хөгжүүлэх зорилгоор Увс аймгийн ИТХ-ын 2008 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн 36-р тогтоолоор анх орон нутгийн хамгаалалтанд авч Гулзат нэрээр нэрлэсэн юм.
- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар 2003 оноос эхлэн хил орчмын ховор амьтад, тэр дундаа аргаль хонь (*Ovis ammon*)-ийг хамгаалах зорилгоор Гулзат орчмын газар нутагт судалгааны ажил хийж ирсэн. Улмаар энэ нутагт нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн загварыг бий болгох зорилгоор 2006 оноос 6 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн юм.
- Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ-ийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийг 2013-2018 онд хэрэгжүүлэв.



ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГАРСАН АМЖИЛТ, ҮР ДҮН:


Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хэмжээг 154 мянган га-р өргөтгөв:

- Гулзат ОНХГ-т хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, нутгийн иргэдээс ирүүлсэн саналыг харгалзан ховор амьтан, ургамал, экосистемийг цогцоор нь хамгаалах зорилгоор ОНТХГ-ын хилийн цэсийг 2015 онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр **76,544 га**-гаар өргөтгөн хамгаалалтад авч Аргаль хонины нүүдлийн коридор нутгийг хамгаалав.
- Цагаан шувуутын улсын ТХГН, Гулзат ОНХГ-ыг холбосон Үүрэг нуур орчмын **77,523 га** газрыг 2017 онд Сагил сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн хамгаалалтад авч Аргаль хонины нүүдлийн коридор нутгийг хамгаалав.



Нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийн бүтэц, зохион байгуулалт бий болсон:

“Гулзат” ОНТХГ-ын удирдлага зохион байгуулалтын бүтэц



- Аймгийн түвшинд Гулзат ОНХГ-ын Удирдах зөвлөл ажиллаж байна.



- Тус ОНХГ-ын хамгаалалтын менежментийг 2011 оноос эхлэн Төрийн бус байгууллага (цаашид менежментийг хариуцагч гэх) аймаг, сумтай байгуулсан гэрээний үндсэн дээр хариуцан тус хамгаалалттай газарт байгуулагдсан нөхөрлөлүүдтэй хамтран хэрэгжүүлж байна.
- Гулзат ОНХГ-ын менежментийг хариуцагч ТББ-ын менежментийн бүтэц шинэчлэн зохион байгуулагдаж өмнө нь байсан аймаг, сумын удирдлага зөвлөлөөс гарч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд нөхөрлөлийн гишүүд дангаараа орсон. Ингэснээр Гулзатын хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын удирдах, хэрэгжүүлэх, хянах үүрэг тодорхой болж нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын хамтын менежментийн зохистой механизм бүрдсэн.
- Таван нөхөрлөл шинээр байгуулагдаж тус ОНХГ-т амьдарч буй **нийт өрхийн 80 гаруй хувь нь (13 нөхөрлөлийн 200 орчим өрх)** нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж Гулзат ОНХГ-ын хамгаалалтын менежментэд идэвхтэй оролцож байна.
- Нийт **14 Идэвхтэн байгаль хамгаалагч** хариуцан хамгаалж буй газар нутагтаа зэрлэг амьтны мониторинг, эргүүл хяналтийг хийж байна.

Боловсруулан хэрэгжүүлж буй баримт бичгүүд:

- Гулзат ОНХГ-ын урт хугацааны стратеги (2015-2025)
- Дунд хугацааны менежментийн (2015-2019) болон ан агнуурын менежментийн төлөвлөгөө (2015-2016)
- ОНХГ-ын Бизнес төлөвлөгөө (2015-2018) зэрэг баримтууд боловсруулагдан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлагдан хэрэгжиж байна.
- Гулзат ОНХГ-ын менежментийг хариуцагчийн үйл ажиллагааг дэмжих дүрэм, журам шинээр болон шинэчлэгдэн боловсруулагдаж, аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан. Үүнд:
 - o ТББ-ын дүрэм, гишүүнчлэлийн журам, удирдах болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, зээлийн эргэлтийн сангийн журам, зээлийн гэрээний загвар
 - o Аймаг, сумын ИТХ-ын 10 гаруй тогтоол (хилийг өргөтгөх, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцуулах, менежментийн төлөвлөгөө батлах, ТББ-д төрийн зарим чиг үүргийг хариуцуулах, агнуурын орлогын эргэн зарцуулалт, г.м.)



ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал нэмэгдсэн:

- Төсөл хэрэгжих хугацаанд Гулзат ОНХГ-ын менежментийн үр ашигт байдал **52%**-р өсч оноо нь 2013 онтой харьцуулахад **36**-аас **75**-д хүрсэн ба 2017 оны сүүлчээр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт **75%**-тай байв.

Тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр - агнуурын орлогын эргэн зарцуулалт өссөн:

- Гулзат ОНХГ-ын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болох спорт агнуураас орон нутгийн төсөвт орох хэмжээ төсөл хэрэгжих хугацаанд **70%**-иар, эргэн зарцуулалт **3,4** дахин нэмэгдсэн.

Түлхүүр зүйлийн тоо толгой өссөн:

- Аргаль хонь (*Ovis ammon ammon*)-ны тоо толгой төсөл хэрэгжих хугацаанд **34%**-иар, 2003 онтой харьцуулахад **90%**-иар буюу **9** дахин өссөний зэрэгцээгээр тус газрын байгалийн нөөцийн ашиглалт (ялангуяа аргаль хонины спорт агнуур), менежментийн амжилт, сургамж нь энэ чиглэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндэслэл болж байна. (Эх үүсвэр: Дэлхийн байгаль хамгаалах сангийн судалгааны тайлан)
- Хар сүүлтийн тоо толгой өсч нутагшил тэлсэн. (нутгийн иргэд, аймаг, сумын удирдлага, албан хаагчдын аман мэдээгээр)



Менежментэд оролцогч талуудын идэвх санаачилга эрс дээшилсэн:

- Нөхөрлөлүүдийн байгаль хамгаалах санаачилгыг хөхиүлэн дэмжих, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор нийт 35,4 сая төгрөгний 9 жижиг төслийг хэрэгжүүлсэн. Үүнээс 23,4 сая төгрөгийг төслөөс, 10,0 сая төгрөгийг нөхөрлөлүүд өөрсдийн хөдөлмөр болон бусад зардлаар гаргасан. Үүний үр дүнд 3 булгийн эх хамгаалагдаж 50 гаруй өрхийн 30 гаруй мянган малын усны асуудлыг урт хугацаанд шийдвэрлэх боломжтой болж, 16 өрх малын тэжээл тариалж сурсан ба 8 өрх гутал, арьс ширний үйлдвэрлэлээ өргөжүүлэн зах зээлд холбогдсон.
- 2016-2017 онд сумдын ЗДТГ-тай хамтран нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагч нарын дунд уралдаан зарласан ба нөхөрлөлийн эхний 3 байр нийт 6,1 сая төгрөг, шилдэг 3 идэвхтэн байгаль хамгаалагч 7,1 сая төгрөгний үнэ бүхий шагнал тус тус хүртэж нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа эрс идэвхжиж, идэвхтэн байгаль хамгаалагч нарын мэдлэг, ур чадвар дээшилсэн.

- Гулзат ОНХГ нутагт байрлах Бөхмөрөн сумын Хар Алтат, Гурван жигэртэй баг, Сагил сумын Үүрэг нуур багийн төвийн засвар, тохижилтийн ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран хийснээр багийн нийт малчдад сургалт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах тохилог байртай болсон.
- Байгалийн нөөцийн хамтын менежмент, хууль эрх зүй, байгаль орчны төлөвлөлт, санхүүжилт, зэрлэг амьтны мониторинг судалгааны арга зүйн хээрийн болон танхимын сургалт, нөхөрлөл хөгжлийн наадам, туршлага судлах аялал зэрэг арга хэмжээг шат дараатай зохион байгуулж давхардсан тоогоор нийт **1800** орчим хүн хамрагдсан.
- Менежментийг хариуцагч байгууллага, идэвхтэн БХ нар, нөхөрлөлүүдэд 17,7 сая төг, аймгийн БОАЖГ-т 7,9 сая төг, аймгийн ГХБХБГ-т 7,1 сая төг, Бөхмөрөн сумын ЗДТГ-т 6,8 сая төг, Сагил сумын ЗДТГ-т 3,7 сая төг, аймгийн ОБЕГ-т 1,4 сая төг, Увс нуурын ДЦГ-ын хамгаалалтын захиргаанд 2,0 сая төг, нийт **38,6 сая төгрөгний** үнэ бүхий тоног төхөөрөмжийг тус тус олгосноор Гулзат ОНХГ-ын хамгаалалтын менежментэд оролцогч талуудын чадавхи бэхжиж, ажиллах нөхцөл сайжирсан.



Гулзат ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан ТЭРГҮҮН ТУРШЛАГА


- Улсын болон ОНХГ-ыг холбосон аргаль хонь, хар сүүлтэй зэрэг ан амьтдын нүүдлийн коридор нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг ландшафтын түвшинд хамгаалах боломж бүрдсэн.
- Менежментийг хариуцагчийн удирдах болон хяналтын зөвлөлийг дан ганц нөхөрлөлүүдийн төлөөллөөр бүрдүүлсэн нь нутгийн иргэдийн шийдвэр гаргах, төлөвлөх, хянах үйл явцад жигд оролцох, харин өмнө нь байсан аймаг, сумын удирдлагын хяналт тавих, бодлогоор дэмжих эрх, үүргийг тодорхой болгосон.
- ОНХГ-т амьдарч буй айл өрхийн 80 гаруй хувийг хамгаалалтын менежментэд оролцуулснаар 2 сумын малчдад агнуурын ашиг орлогоос тэгш хүртэх боломжийг олгож, энэ нь эргээд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах хөшүүрэг болж байна.
- Хамгаалалтын менежментэд Увс нуурын ай савын ТХГ-ын хамгаалалтын захиргааг татаж оролцуулсан нь идэвхтэн байгаль хамгаалагч нарын мониторинг, судалгаа, эргүүл хяналт хийх чадавхийг бэхжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.
- Гулзат ОНХГ-ын санхүүжилтийн гол эх үүсвэр болох спорт агнуурын орлогыг төвлөрүүлэх, хуулийн дагуу эргэн зарцуулах талаар сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг аймаг, сумын санхүү, аудитын нэгж, Төрийн сан, ИТХ-ын төлөөлөгч нарт шат дараатай хийснээр эргэн зарцуулалтын хувийг нэмэгдүүлж чадсан.






Гулзат ОНХГ-т төсөл хэрэгжүүлснээр гарсан СУРГАМЖ

1. Менежментийг хариуцагч хуулийн этгээдтэй байгуулсан гэрээг дүгнэх, үнэлэх механизм тодорхой байх шаардлагатай. Үүнд:
 - a. гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг (*ОНХГ-ын үнэт зүйлс, экосистем, биологийн олон янз байдлын төлөв байдлыг суурь нөхцлөөс дордуулахгүй байх, сайжруулах, биологийн төрөл зүйлд учирч байгаа аюул заналыг бууруулах арга хэмжээг тодорхойлох г.м.*) тогтоож гэрээний салшгүй хэсгээр авч үзэх;
 - b. менежментийг хариуцагчийн хэнд, хэзээ тайлагнах талаар гэрээнд тодорхой зааж өгөх;
 - c. гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, гэрээг сунгах, цуцлах талаар албан ёсны шийдвэр гаргаж менежментийг хариуцагчид мэдэгддэг байх;
2. Байгаль хамгаалах нөхөрлөлүүд нь менежментийг хариуцагч ТББ-д гишүүнчлэлийн эрхтэй, тухайн ТББ-ын шийдвэр гаргах дээд бүтэц болох Удирдах зөвлөл/хороог бүрдүүлэх;
3. ОНХГ-ын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, төлөвлөгөөнд тодорхойлсон зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй эсэхэд хамтын оролцооны аргаар 2 жилд нэг удаа үнэлгээ хийх (*"Хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээ" МОН-МЕТТ аргазүй*)
4. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үндсэн санхүүжилт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах" журмаар зохицуулагдаж байдаг. Тиймээс цаашид 43-р тогтоолын хэрэгжилтийг хангах, мөн нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх;
5. Трофейн агнуурын квотыг шинжлэх ухааны үндэстэй, нээлттэй хуваарилах, агнуурын компаниудын сонгон шалгаруулалтад нөхөрлөл, менежментийг хариуцагчийн саналыг давуу эрхтэйгээр үндэслэн нээлттэй, онлайн хэлбэрээр явуулах, аргаль хонины лицензийн тарифыг олон улсын зах зээлийн үнэлгээтэй нийцүүлэх, аргалийн агнуурыг байгаль хамгаалах хэрэгсэл болгох талаар холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох.
6. Аргаль хонь, бэлчээрийн малын давхцал, уул уурхайн хөгжил нь аргаль хонины тогтвортой байрших нөхцлийг алдагдуулах, голомт нутгаасаа дайжих эрсдэл байгаа тул агнуурын орлого өндөр байгаа ойрын жилүүдэд энэ талын нарийвчилсан судалгаа, үнэлгээг хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх нь зүйтэй.



“ГУЛЗАТ” ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - www.undp.mn

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар - www.mpa.gov.mn